



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
АРБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 18 өдөр

Дугаар А/119

Мандал

**Хөрөнгө зарцуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, 41.2.3 дахь заалт, Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 14 дүгээр хуралдааны 05 тогтоолын 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр сумын төвийн зам засварын арчлалтын ажилд 4,800,000 (дөрвөн сая найман зуун мянга) төгрөгийг зарцуулсугай.

2.Дээрх хөрөнгийг орон нутгийг хөгжлийн сангийн зардлаас тооцож олгохыг нягтлан бодогч (Г.Дэлгэрцэцэг)-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилт болон зардлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Санхүү албаны дарга (Б.Цэндбаяр)-д даалгасугай.

ДАРГА  Б.ГАНТУЛГА

